



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2005 оны 07 сарын 27 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 7 дугаар сарын 15-ны болон 2003 оны 12 дугаар сарын 22-ны өдрүүдийн хурлын тэмдэглэл, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г үндэслэн ТУШААХ нь:


1. Бадарч овогтой Баярмааг АНУ-ын Калифорнийн Улсын их сургуулийн магистрантурт боловсролын чиглэлээр, Чулуунбат овогтой Оюунбилэгийг АНУ-ын Стрэтфорд Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 7 дугаар сарын 20-ний өдрийн 240 дугаар тушаалын Бадарч овогтой Баярмаатай холбогдолтой хэсгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 438 дугаар тушаалын Чулуунбат овогтой Оюунбилэгтэй холбогдолтой хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2004-2005 тушаалд кодификаци хийгдэв.

2003-2004 тушаалд кодификаци хийгдэв.



П.ЦАГААН

3725188